


КОРОНАВИРУСЫЙН ӨВЧИН 2019 (COVID-19)

ТА ЮУ МЭДЭХ ХЭРЭГТЭЙ ВЭ

Энэ бол шинэ коронавирус бөгөөд 2019 оны 12-р сард БНХАУ-ын Ухань хотод анх илэрсэн.

ДАМЖИХ ЗАМ Судалгаа хийгдсээр байна

- Хүмүүс ярих, ханиах, найтаахад голдуу агаар дуслын замаар дамждаг.
- Халдвартай дуслар бохирдсон зүйлд хүрэхэд таны гарт наалдаж улмаар таны хамар / нүд / ам руу орох боломжтой.



Жуулчид вирусийг бусад улс оронд тараасан. **Нэвтрэх хэсэгт скрининг хийх** нь өвчтэй жуулчдыг ирүүлэхэд тустай.

ШИНЖ ТЭМДЭГ Шинж тэмдэг өртөлтөөс хойш 14 өдрийн дотор илрэх боломжтой. Биеийн байдлаа хяна!

- Халуурах
- Ханиалгах
- Хоолой хөндүүрлэх
- Ядрах
- Амьсгаадах
- Үнэрлэх, амтлах чадвараа гэнэт алдах
- Толгой өвдөх / булчингаар өвдөх
- Гүйлгэх



Ихэнх тохиолдол нь **ХӨНГӨН** боловч зарим нь **ХҮНД**, амь насанд аюултай.



Хэрэв та халдварт өртсөн эсвэл шинж тэмдэг илэрсэн бол **нэн даруй эмнэлгийн тусламж ав.**




УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ



Хэрэв танд шинж тэмдэг илрэхгүй эсвэл хөнгөн илэрвэл гэртээ байж, эмнэлгийн тусламж ав. Орон нутгийн зөвлөмжийг дага.

Томуугийн вакцин хийлгэ – ингэснээр COVID-19 өвчнийг улирлын томуутай андуурах эрсдэлийг бууруулна.



Хувийн ариун цэврийг сайтар сахь:

- Гараа тогтмол угаа. Гар угаах ус, савангүй бол спиртэн суурьтай гар ариутгагч хэрэглэ.
- Ханиах, найтаахдаа хамар, амаа тагла.
- Нүүрэндээ гараа бүү хүргэ (нүд, хамар, ам) – ялангуяа олон хүн хүрдэг эд зүйлсд хүрсний дараа (жишээ нь шатны хашлага, хаалганы бариул).
- Хүнс, унд, гар утас зэрэг хувийн эд зүйлсийг дундаа бүү хэрэглэ.

Халдварт өртөхөөс зайлсхий:

- Бусад хүмүүсээс дор хаяж 1-2 метрийн зай барь.
- Олон хүн хүрдэг эд зүйлсийг өдөр бүр тогтмол цэвэрлэж, ариутга. Хэрэв бохирдсон гэж үзвэл ойрхон ойрхон цэвэрлэ.
- Өвчтэй хүнээс хол бай. Өөр рүүгээ бүү ханиалгаж, найтаалгуул.
- Олон хүн цугларсан арга хэмжээнд оролцохоос зайлсхий.
- Гар барих, үнсэх, тэврэхээс зайлсхийж гараараа даллах, мэхийн ёслох, толгой дохиж зэрэг соёлын хувьд тохиромжтой байдлаар 1-2 метрийн (3-6 тохой) зайнаас мэндлэ.
- Эмнэлэгт үзүүлэх шаардлагагүй бол эмнэлэгт бүү оч.
- Хэрэв та өвдсөн бол бүү аял.
- Шаардлагагүй аялалаас зайлсхий. Боломжтой бол гэрээсээ ажилла.

ЭМЧИЛГЭЭ: Тусгай эмчилгээ байхгүй. Дэмжих эмчилгээ нь шинж тэмдгийн бууруулахад тустай.

COVID-19 эсрэг **вакцин байхгүй.**



Интернэйшнл СОС тусгайлан бэлдсэн <https://pandemic.internationalsos.com/2019-ncov> цахим хуудаснаас шинэ мэдээлэл авах боломжтой.

АНХААРУУЛГА: Энэхүү зурагт хуудас нь зөвхөн мэдээллийн зориулалтай. Үүнийг мэргэжлийн эрүүл мэндийн зөвлөгөөнд ашиглаж болохгүй. Энэхүү зурагт хуудсан дахь мэдээллийн талаар асуулт байвал эмчид хандана уу.

© 2020 Интернэйшнл СОС. Бүх эрх нь хамгаалагдсан. Зөвшөөрөлгүй хувиалан олшруулах, тараахыг хориглоно.

17/08/2020 – 5.2 –р хувилбар

